



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар

Д/118

Хэрлэн сум

Хөтөлбөр хэрэгжүүлэхэд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Оюунлаг, Спортлог, Хэнтийчүүд” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас ажил гүйцэтгэх гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
дугаар сарын 06-ны өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

“ОЮУНЛАГ ХЭНТИЙЧҮҮД” төслийн хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Төсвийн задаргаа	Санхүүжилтийн хуваарь					Нийлбэр дүн
		2 сар	3 сар	4 сар	6 сар	9 сар	
1	Төслийн багийн ахлагчийн хөлс	1,000,000					1,000,000
2	Төслийн сургагч багшийн хөлс	1,000,000					1,000,000
3	Бүх сумдаар тойрч сургагч багш бэлтгэх, дадлагажуулах/1 удаа/		5,000,000				5,000,000
4	Сургууль, цэцэрлэгийн шатрын Багш нарыг аймгийн төвд цуглуулж сургалт зохион байгуулах / 2 удаа/					4,000,000	4,000,000
5	Орон нутгийн онцлог тохирсон сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, гарын авлага, заах арга зүйн зөвлөмжийг боловсруулж, хэвлэх /ном, цаасан болон цахим/			5,000,000			5,000,000
6	Цахим хичээл, товхимол хэвлүүлэх				4,000,000		4,000,000
	<b>Нийт</b>	<b>2,000,000</b>	<b>5,000,000</b>	<b>5,000,000</b>	<b>4,000,000</b>	<b>4,000,000</b>	<b>20,000,000</b>